

Жалзэ тэмбан Ганжуурын гарчгийн тухайд (= О гарчаке (оглавлении) тибетского рукописного Ганджура под названием «Rgyal-rtse Them-spang-ma»)

*Мөнх-Отгон Д.*¹

¹ Институт языка и литературы Академии наук Монголии (д. 54а, пр-т Энхтайван, район Баянзурх, 13330 Улан-Батор, Монголия)
научный сотрудник, докторант
E-mail: otguld@gmail.com

© КалмНЦ РАН, 2020
© Мёнх-Отгон Д., 2020

Аннотация. Автор дает описание оглавления 111-томного рукописного Ганджура (Кангьюра) (тиб. Rgyal-rtse Them-spang-ma), записанного красивым почерком черными чернилами на тибетской бумаге. Этот Ганджур, привезенный из Тибета в дар Богдо гэгэну в 1671 г., отличается тем, что, возможно, это самая точная (безошибочная) версия из многих рукописных собраний Ганджура. Поскольку именно этот рукописный Ганджур является основным источником для определения и сверки при изучении первой части канонического свода, его можно расценивать как один из самых важных первоисточников, который имеется в нашем распоряжении. На сегодняшний день существует много ксилографических изданий Ганджура и его оглавлений, при этом в них варьируется количество томов, титулов сочинений, в зависимости от того, какое это печатное издание, соотношение количества томов и сочинений в них будет различаться. Поэтому актуально ввести в научный оборот гарчак (оглавление) рукописного Ганджура (Rgyal-rtse Them-spang-ma), сделать его доступным широкому кругу читателей, ученых, священнослужителей и верующих. В библиотеке автор статьи обнаружил две рукописи оглавления описываемого канонического свода, одна из которых была опубли-

кована в серии в журнале «Тибетологические исследования» Института языка и литературы Академии наук Монголии. В настоящей статье представлен краткий обзор этих рукописей.

Ключевые слова: Национальная библиотека Монголии, Ганджур (Кангьюр) Rgyal-rtse Them-spang-ma, гарчак (оглавление), перечень

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Мөнх-Отгон Д. Жалзэ тэмбан Ганжуурын гарчгийн тухайд (=О гарчаке (оглавлении) тибетского рукописного Ганджура под названием «Rgyal-rtse Them-spang-ma») // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 1. С. 65–73. DOI: 10.22162/2587-6503-2020-1-13-65-73

UDC 294.321+821.584.6+821.512.36

DOI: 10.22162/2587-6503-2020-1-13-65-73

On the garchak (table of contents) of the Tibetan handwritten Ganjur called “Rgyal-rtse Them-spang-ma”

*Munkh-Otgon D.*¹

¹Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia
(54a, Enkh-taivan ave., Bayanzurkh distr., Ulan Bator 13330, Mongolia)
Research Associate, Doctoral Student
E-mail: otguld@gmail.com

© KalmSC RAS, 2020

© Munkh-Otgon D., 2020

Abstract. The article gives description of the table of content of the 111-volume handwritten Ganjur (Kangyur) (tib. Rgyal-rtse Them-spang-ma) written in a

beautiful handwriting in black ink on Tibetan paper. This Ganjur, brought from Tibet as a gift to Bogdo gegyan in 1671, stands out by the fact that it might be the most accurate (without mistakes) version of many handwritten collections of Ganjur. As this handwritten Ganjur is the main source for determining and checking in the study of the first part of canonical summa, it can be considered one of the most important primary sources that is available for us. Nowadays, there are many xylographic publications of Ganjur and its table of content with the variations in number of volumes and titles of the works and depending on the type of publication the correlation of the number of volumes with the works in them will vary. Thus, it is relevant to introduce garchak (the table of content) into the science, make it available for a wide range of readers, scholars, clergy and believers. In the library the author found two manuscripts of the table of content of the canonical summa in question, one of them was published in the series in the journal “Tibetan Studies” of the Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia. The article gives a brief review of these manuscripts.

Keywords: National Library of Mongolia, Ganjur (Kangyur) Rgyal-rtse Them-spang-ma, garchak (table of content), list

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Munkh-Otgon D. On the garchak (table of contents) of the Tibetan handwritten Ganjur called “Rgyal-rtse Them-spang-ma”. In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 1. Pp. 65–73. DOI: 10.22162/2587-6503-2020-1-13-65-73

Эдүгээ Монгол Улсын Үндэсний номын сан (МУҮНС)-ийн төвд номын хөмрөгт «Жалзэ Тэмбан Ганжуур» (төвд *Rgyal-rtse Them-spang-ma*) хэмээн нэрлэгддэг 111 боть гар бичмэл Ганжуур хадгалагдаж буй. Энэ тухай Л. Хүрэлбаатар багш «Судар шаштирын билиг» номдоо «...УТНС-ийн төвд хөмрөгт байгаа ховор чухал бөгөөд түүхэн хэрэг явдалд холбогдох Ганжуурын дурсгалуудын дотор “Жалзэ-Тэмбам” хэмээх 111 боть, маш сайхан хичээнгүй нарийн үсэгтэй, бичмэл Ганжуур байгаа юм.

Үүнийг төвдийн Бүдон гэгээн мутраараа бичиж бүтээсэн хэмээн хуучдын үгэнд ярих боловч, харин төгсгөлийн үгэнд бичсэнээр бол уг Ганжуур нь Бүдон гэгээний сайтар нарийвчлан нуталж, ариутган шүүсэн судрын эх болгож бүтээсэн тухай дурдаж байна. Энэ Ганжуурыг 1671 онд Төвдийн газраас Халхын Өндөр гэгээнд залуулсанд “Халхад урьд гараагүй гайхамшиг тансаг болов” хэмээн төвд сурвалжуудад онцлон тэмдэглэжээ. Жалзэ-тэмбам хэмээх төвд үгийг хуучдын үгэнд Төвдийн Жалзэ хааны зарлигаар босго давуулж, гадагш гаргахыг хорьсон, хатуу цаазтай нандин эрхмийн ном болохыг заасан үг гэх боловч, угтаа Ганжуурын хамгийн мадаггүй, дээд зэргээр шалган байцааж, зөв эхийн гэрч тэмдэг болгосон бичмэл Ганжуур юм. Энэ бол Ганжуурын судлалд зөв эхийг байцаан тогтоох гол сурвалж болж буйгаараа өнөө хир төвдөд өөрт нь байхгүй байгаа эрхмийн эрхэм нандин болно» хэмээн нухацтай дурджээ [Хүрэлбаатар 2002: 53].

Төвдийн Жалзэгийн (rgyal rtse) хаан Равдангүнсэнпаг (rab brtan kun bzang 'phags) төвд бичмэл Нартан Ганжуурыг үндэс болгож үүнийг бүтээлгээд «Жалзэ Тэмбанма Ганжуур» (rgyal rtse them sprang ma bka' gyur) гэж алдаршсан байна.

«Тэмбанма» хэмээх үгийн «тэм» (them) гэж ‘байцаан барих’, «тэмжай» (them byas) гэж ‘тэмдэг бичиг’, «тэмьиг» (them yig) гэж ‘данс бичиг’, «банма» (drang ma), «банжа» (drang rgya) гэж ‘гэрч тэмдэг’, ‘хүндлэл тэмдэг’, ‘гэрч’ гэсэн, угтаа ‘байцаан шалгасан гэрч тэмдэг’ гэсэн үг юм [Хүрэлбаатар 2002: 53].

Энэ гар бичмэл нь Ганжуурын хувилбаруудын баруун жигүүрт чухал үүрэг гүйцэтгэсэн боловч Доктор Аймерийн (H. Eimer) үзэж буйгаар [Eimer 2002] энэ гар бичмэлийн тухайд уг бүтээлийг эмхтгэж бүтээсэн цаг хугацаа, өнөө үеийг хүртэл хадгалагдаж байгаа эсэх талаар тодорхойгүй зүйлүүд бий хэмээн үзжээ [Bethlenfalvy 1982: 6].

Уг Ганжуурыг тавдугаар Далай лам Лувсанжамц (rgyal ba lnga pa chen po Blo bzang rgya mtsho, 1617–1682) Төвдийн газраас Өндөр гэгээн Занабазарт (rje btsun bstan pa Blo bzang bstan pa'i rgyal mtshan, 1635–1723) 1671 онд бэлэглэсэн болох нь түүхэн сурвалжийн мэдээ сэлтээс үзэхэд илэрхий юм.

Төвдийн хааны номын санд байхдаа энэ Ганжуур нь зандан хавтастай, мөнгөн хуйтай байсан гэдэг. Төвдүүд Өндөр гэгээнд өгөх гэлээ хэмээн дургүйцээд зандан хавтас, мөнгөн хуйг нь авч үлдээд ачуулсан төдийгүй араас нь цэрэглэн иржээ. Үүнийг Өндөр гэгээн рид хувилгаанаар мэдээд номоо хавцалд нуугаад ганцаараа хүлээж байж. Тэгээд Төвдүүдийг ирэхэд «Жалзэ Тэмбан» хурдан өртөөгөөр явсан, одоо бараг Монголын хилд орсон гэж хэлсэн байна. Түүнээс хойш Ганжуурыг нуусан хавцлыг «Ганжуурын хавцал» гэж нэрлэх болсон бөгөөд Хятадын Ганьсу мужид Хатан голын наад эрэгт байдаг гэдэг. Гурван боть нь дутуу. Түүний нэгийг нь Жаран Хашорын суварганы шүншигт, нэгийг нь сүмийн дээвэрт, нөгөөг нь Жанрайсигийн шүншигт хийсэн гэж ярилцдаг хэдий ч баттай бус юм. Учир нь төвдүүд монголд өгөх дургүй байсан тул ачуулахдаа аваад үлдсэн ч юм уу, аль эсвэл ачиж ирж байх замдаа алга болсон ч байж болохыг үгүйсгэх аргагүй. 1925 онд Богдын Цагаан ордноос хураагдаж, МУҮНС-д ирсэн байна. Нийт 111 боть байхаас 110 нь төвд номын хөмрөгт, 1 боть нь үнэт ховор номын хөмрөгт хадгалагдаж байна.

«Тэмбан» Ганжуур нь хүнд, шаравтар, гөлгөр төвд цаасан дээр хятад хар бэхээр бичсэн гоёмсог гар бичмэл юм. Энэ Ганжуурын цаасны хэмжээ нь 70,5x25,2 см, бичвэрийн хэмжээ нь 59,0x14,5 см, нэг хуудсанд байх мөрийн тоо 8. Мөн хуудас бүрийн 4 дэх мөрөнд буюу голын мөрөнд улаан бэхээр хоёр дугуй тэмдэглэгээ тавьсан байдаг.

«Жалзэ Тэмбан» Ганжуурын бүтэц:

1. Винай [төвд *'dul ba*] 14 боть (ka–pha)
2. Барамид [төвд *sher phyin*]
 - а. юм [төвд *'bum*] 16 боть (ka–ma)
 - б. Хоёр түмт [төвд *nyi khri*] 4 боть (ka–nga)
 - в. Түм найман мянгат [төвд *khri brgyad*] 3 боть (ka–ga)
 - г. Билиг түмт [төвд *shes khri*] 2 боть (ka–kha)
 - д. Найман мянгат [төвд *brgyad stong pa*] 1 боть (ka) **байхгүй**
 - е. Элдэв түмт [төвд *sher phyin sna tshogs*] 1 боть (ka) **байхгүй**
3. Олонхи [төвд *sangs rgyas phal bo che*] 6 боть (ka–cha)
4. Эрдэнэ давхарлаг [төвд *dkon mchog brtsegs pa*] 6 боть (ka–cha)

5. Судар [төвд *mdo sde*] 37 боть (ka–ji) (ga) **боть байхгүй**
6. Нирваан [төвд *myang 'das*] 3 боть (ka–nga)
7. Нинжүд [төвд *rnying rgyud*] 3 боть (ka–nga)
8. Дандар [төвд *rgyud*] 18 боть (ka–tsha)

Төвд хэлээрх гар бичмэл болон барын судрын асар их цуглуулгыг системчлэх, бүртгэх, тодорхойлох шаардлага цаг хугацааны явцад тулгарч, төвдүүд олон зүйл гарчиг хийж ирсэн уламжлал нь хожим төвд судлалын бие даасан тусгай салбар болж хөгжихөд нөлөөлсөн байна [Бүрнээ 2013: 46].

Гарчиг (*dkar chag*, *kar chags*) гэдэг нь тоо тэмдэглэл, данс бичиг гэсэн утгатай төвд үг бөгөөд өдгөө монгол хэлний уугуул үг мэт болжээ. Гарчиг нь хэдийгээр цөөн хуудас боловч маш их агуулга, мэдээллийг багтаасан дурсгал юм.

«Жалзэ Тэмбан» Ганжуурын гарчгийн тухайд уг эх судартай ижил хэмжээ, цаас бүхий гарчиг үгүй. Энэ нь «Жалзэ Тэмбан» Ганжуурыг анхлан бүтээхдээ гарчгийг хамтад нь үйлдээгүй гэсэн үг хараахан бус юм.

Унгарын эрдэмтэн Г. Бетленфальви 1982 онд «Жалзэ Тэмбан» Ганжуурын ерөнхий гарчгийг хийхдээ Зая бандидын «Сонссоны тэмдэглэл»-д бичсэнийг [*Dza ya ranti ta*] ашигласан болохоо дурдсан байна [Bethlenfalvy 1982: 8]. Түүний судалгааны эргэлтэд оруулсан эл гарчиг нь эдүгээ МУҮНС-ийн төвд номын хөмрөгт бий. Цаасны хэмжээ нь 40,5x14,0 см, бичвэрийн хэмжээ нь 30,5x9,5 см, нийт 221 хуудас, шинэ орос цаасан дээр харандаагаар шугам татаж, хар бэхээр, 6 мөрөөр бичсэн гар бичмэл гарчиг юм. Энэ гарчиг нь бүрэн биш бөгөөд алга болсон ботиудыг дурдалгүй орхисон байна. Мөн судрын аймгийн GA ботийг тэмдэглэх газар GI ботийг андууран тэмдэглэсэн байна.

Энэхүү жагсаалтдаа тэрээр «Жалзэ Тэмбан» Ганжуурын 114 ботийн (алга болсон гэх гурван боть, ботийн доторхи номын жагсаалтыг «Сонссоны тэмдэглэл»-ээс нөхөж оруулсан), 8 аймгийн, нийт 834 зохиол байна гэж үзжээ.

Үүнээс гадна уг Ганжуурын өөр нэгэн гар бичмэл гарчиг МУҮНС-д хадгалагдаж буй. Энэ гарчгийн цаасны хэмжээ нь: 35,0x11,0 см, бичвэрийн хэмжээ нь: 29,5x8,5 см, хуучивтар орос

цаасан дээр хар бэхээр, нэг хуудсанд 10 мөрөөр бичсэн, 11 хуудас (5-р хуудас нь дээд, доод гэсэн 2 хуудас) гар бичмэл.

Гарчиг нь эхлэл, төгсгөлийн тэмдэглэл гэх зүйл байхгүй учир чухам хэдийд, хэн, ямар зорилгоор бичсэн болох нь тодорхойгүй. Хэдий цөөн хуудастай, чухаг мэдээ сэлтээр ховор боловч «Жалээ Тэмбан» Ганжуур дахь зохиолуудыг бүртгэхэд нэгэн чухал хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй.

Энэ гарчгийн гол онцлог нь:

- Гезагуайн (G. Bethlenfalvy) барьсан гарчигт тэмдэглэгдээгүй үлдсэн зарим нэг зохиолыг энэ гарчигт байна.

Тухайлбал:

- Судрын аймгийн 21 дүгээр ботид «Би үгүйн асуусан нэрт их хөлгөн судар» ном Геза гуайн гарчигт тэмдэглэгдээгүй. Харин эл гарчигт «bdag med pa dris pa» хэмээх товч нэрээрээ 2б талд байна.
- Номын нэрсийг товчоор тэмдэглэсэн
- Дутуу гурван боть, ботийн доторхи зохиолуудыг бүртгэсэн
- Бүртгэлгүй үлдсэн зохиолыг нэмж оруулахыг заасан 10 орчим тусгай тэмдэглэгээтэй
- Банзрагч, Төмрийн таван аймаг, Шадар найман хөвгүүний зуун найман нэр, тарни, тогтоол гэх мэтчилэн түүн дотор багтах зохиолуудыг нэгтгэн нэрлэсэн гэх мэт

Жишээлбэл: «Шадар найман хөвгүүний зуун найман нэр, тарни, тогтоол» (nye ba'i sras brgyad kyi mtshan brgya rtsa brgyad gzungs) хэмээн тэмдэглэсний дотор

- Spyau ras gzigs dbang phyug gi mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Byams pa'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Nam mkha'i snying po'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Kun tu bzang po'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Lag na rdo rje'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa

- 'Jam dpal gzhon nur gyur pa'i mtsah brgya brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Sgrib pa thams cad rnam par sel ba'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa
- Sa'i snying po'i mtshan brgya rtsa brgyad pa gzungs sngags dang bcas pa гэсэн 8 зохиолын нэрийг хураангуйлан нэрлэсэн байна.

Уг гарчиг нь судрын аймгаас эхлэн бүртгэсэн байсан тул тэр дарааллаар, нийт номыг 1 гэсэн дугаараас эхлэн, зарим газарт орхигдсон ном зохиолын гарчгийг эх судраас нь шүүн жагсааж оруулсны эцэст миний бие «Жалзэ Тэмбан» Ганжуурт нийт 824 зохиол байна гэж үзсэн билээ. Ингэхдээ гарчигт Нинжүд аймгийг бүртгэлгүй орхисон байсныг төгсгөлд дугаарлан оруулсан болно. Гарчиг дахь аймгуудын дараалал:

1. Судрын аймаг (mdo sde)
2. Дандар (rgyud)
3. Нирваан (myang 'das)
4. Билиг барамид (shes rab kyi pha rol tu phyin pa)
 - а. Юм (yum 'bum)
 - б. Хоёр түмт (nyi khri)
 - в. Түм найман мянгат (khri brgyad stong pa)
 - г. Билиг түмт (shes khri)
 - д. Найман мянгат (brgyad stong pa)
 - е. Элдэв билиг барамид (sher phyin sna tshogs)
5. Эрдэнэ давхарлаг (dkon brtsegs)
6. Олонхи (phal bo che)
7. Винай ('dul ba)
8. Нинжүд (rnying rgyud).

Энэ гарчгийг Зая гэгээний «Сонссоны тэмдэглэл» (thob yig)-д бичсэнтэй тулгаж үзэхэд Винайн аймгийн зохиолуудыг хэрхэн тэмдэглэсэн байдал нь үг үсэггүй таарч байсан учир «Сонссоны тэмдэглэл»-ээс, мөн Винайн аймгийн 14 дүгээр боть буюу (РНА) ботийн төгсгөлийн үгээр энэхүү гарчгийг төгсгөсөн буй нь «Жалзэ Тэмбан» Ганжуурыг ашиглаж бичсэн бололтой. Дээрх хоёр гарчгаас гадна миний бие саявтар Улсын номын санд уг

Ганжуурын өөр нэгэн бичмэл гарчгийг үзсэн бөгөөд энэ талаар дараа дэлгэрэнгүй танилцуулахаар зэхэж байна. Энэ мэт нэгэн номын хэдэн зүйл бичмэл гарчиг олдож байгаа нь бие биедээ үгүй мэдээллийг нөхөх, дутуу бүртгэгдсэн ном судрыг бүрэн гүйцэд болгох зэрэг давуу талтай нь хэнд ч мэдээжийн хэрэг билээ.

Эх сурвалж

Dung dkar tshigs mdzad chen mo. Beijing. 2002.
Rgyal rtse them spang ma bka' 'gyur (mdo) (ka–ji).

Ном зүй

- Бүрнээ 2013 — *Бүрнээ Д.* Төвд Ганжуур Данжуур судлалын чиг хандлагын тухай // Билгийн гэгээ. «Ганжуур Данжуурын судалгаа». Эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхтгэл. Улаанбаатар, 2013. 46 х.
- Хүрэлбаатар 2002 — *Хүрэлбаатар Л.* Судар шастирын билиг. Улаанбаатар, 2002. 53 х.
- Bethlenfalvy 1982 — *Bethlenfalvy G.* A hand list of the Ulan-Bator manuscript of the Kanjur Rgyal-rtse Them-spans-ma. Budapest: Akadémiai Kiadó, 1982. 111 p.
- Eimer 2002 — *Eimer H.* The many canons of Tibetan Buddhism. Boston., 2002. 379 p.
- Dza ya panti ta — Dza ya panti ta Blo bzang 'phrin las. Thob yig gsal ba'i me long. Nga boti.

Handwritten text in Mongolian script, likely a historical document or chronicle. The text is written in a cursive style and includes several large, decorated initial letters (possibly 'A', 'B', 'C', 'D', 'E', 'F', 'G', 'H', 'I', 'J', 'K', 'L', 'M', 'N', 'O', 'P', 'Q', 'R', 'S', 'T', 'U', 'V', 'W', 'X', 'Y', 'Z') marking the beginning of new sections or paragraphs. The text is densely packed and covers most of the page.

Handwritten text in Mongolian script, continuing the historical document or chronicle. The text is written in a cursive style and includes several large, decorated initial letters (possibly 'A', 'B', 'C', 'D', 'E', 'F', 'G', 'H', 'I', 'J', 'K', 'L', 'M', 'N', 'O', 'P', 'Q', 'R', 'S', 'T', 'U', 'V', 'W', 'X', 'Y', 'Z') marking the beginning of new sections or paragraphs. The text is densely packed and covers most of the page.

